

# Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/13/СТА-ТШЗ

|   |  |
|---|--|
| <p>Цахим хуудас:<br/><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Чойр хот<br/>2022 он</p> | <p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br/>тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br/>Утас:70543156 Цахим хаяг: <a href="mailto:Saranmuyab@audit.gov.mn">Saranmuyab@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр<br/>Утас:70543179 Цахим хаяг: <a href="mailto:Naranbayarg@audit.gov.mn">Naranbayarg@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ц.Батсайхан<br/>Утас: 70543179 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhants@audit.gov.mn">Batsaikhants@audit.gov.mn</a></p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

|  |    |
|--|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                  | 5  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                           | 5  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                        | 6  |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....             | 8  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                             | 9  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                         | 11 |
| 3. Аудитын тайлан.....   | 13 |
| 3.1 Ерөнхий зүйл.....  | 13 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                       | 13 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                            | 14 |
| 3.4 Материаллаг байдал .....   | 14 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                  | 14 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....                        | 15 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....                  | 16 |
| 3.8 Аудитын гол асуудал .....  | 17 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 17 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....                            | 17 |
| 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....                                 | 17 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....                                       | 17 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                              | 17 |
| 4. Аудитын илрүүлэлт .....   | 18 |
| 4.1 Залруулсан алдаа.....  | 18 |
| 4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.....                                       | 18 |
| 4.3 Албан шаардлага өгөгдөөгүй.....  | 18 |
| 4.4 Зөвлөмж .....  | 18 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                          | 19 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |   |
|----------|---|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ГСА      | Говьсүмбэр аймаг  |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                       |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2022.02.24 № 08

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Шүүхийн тамгын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Шүүхийн тамгын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4209020025

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код   | Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл / төгрөгөөр / |
|-------|---|----------------|-------------------------------|
| 1     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН   | 4,328,000.00   | 10,133,610.00                 |
| 33    | АВЛАГА  | 0              | 9,693,610.00                  |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 0              | 9,693,610.00                  |
| 35    | БАРАА МАТЕРИАЛ  | 4,328,000.00   | 440,000.00                    |
| 35400 | Хангамжийн материал   | 4,328,000.00   | 440,000.00                    |
| 35410 | Бичиг хэргийн материал  | 2,039,000.00   | 0                             |
| 35420 | Аж ахуйн материал   | 440,000.00     | 440,000.00                    |
| 35440 | Түлш, шатах тослох материал   | 1,849,000.00   | 0                             |
| 2     | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН   | 900,974,994.94 | 916,965.378.05                |
| 39    | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 900,974,994.94 | 916,965.378.05                |
| 39200 | Биет хөрөнгө  | 871,165,411.62 | 887,438,294.77                |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц  | 732,567,454.96 | 732,567,454.96                |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл   | -31,340,562.96 | -47,838,194.64                |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл  | 47,580,000.00  | 142,580,000.00                |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл   | -2,230,000.00  | -19,238,333.35                |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер)                                      | 119,769,120.92 | 145,738,875.92                |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл   | -32,887,236.71 | -94,574,509.74                |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 85,062,748.08  | 85,062,748.08                 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл   | -56,344,589.63 | -65,404,975.86                |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө  | 10,611,689.12  | 10,611,689.12                 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл   | -1,704,212.16  | -2,343,291.72                 |
| 39217 | Ном   | 81,000.00      | 276,832.00                    |
| 39300 | Биет бус хөрөнгө  | 29,809,583.32  | 29,527,083.28                 |
| 39301 | Програм хангамж   | 1,330,000.00   | 1,330,000.00                  |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл   | -80,416.68     | -362,916.72                   |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө  | 28,560,000.00  | 28,560,000.00                 |
| 3     | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II   | 905,302,994.94 | 927,070,798.49                |
| 5     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН  | 905,302,994.94 | 927,098,988.05                |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо   | 905,302,994.94 | 927,098,988.05                |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 180,688,239.00 | 180,688,239.00                |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн  | 408,139,453.56 | 429,935,446.67                |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн  | 313,990,732.21 | 408,139,453.56                |
| 51220 | Тайлант үеийн үр дүн  | 94,148,721.35  | 21,795,993.11                 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 316,475,302.38 | 316,475,302.38                |
| 6     | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           | 905,302,994.94 | 927,098,988.05                |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

|        |   |                  | / төгрөгөөр /    |
|--------|---|------------------|------------------|
| Код    | Үзүүлэлт  | ӨМНӨХ ОН         | ТАЙЛАНТ ОН       |
| I      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                           | 1,124,108,213.52 | 1,080,531,743.00 |
| 12     | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                       | 142,924,513.52   | 108,819,243.00   |
| 120    | Нийтлэг татварын бус орлого                               | 142,924,513.52   | 108,819,243.00   |
| 120009 | Бусад орлого  | 119,052,526.52   | 0                |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө        | 23,033,147.00    | 108,333,587.00   |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал        | 838,840.00       | 485,656.00       |
| 13     | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                             | 981,183,700.00   | 971,712,500.00   |
| 1310   | Улсын төвлөрсөн төсвөөс                                   | 981,183,700.00   | 971,712,500.00   |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                         | 981,183,700.00   | 971,712,500.00   |
| II     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                               | 1,029,959,492.17 | 1,058,735,749.89 |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ   | 1,029,959,492.17 | 1,058,735,749.89 |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                           | 981,312,392.17   | 1,029,856,306.14 |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                         | 749,433,358.00   | 737,154,014.00   |
| 210101 | Үндсэн цалин  | 606,435,958.00   | 617,531,200.00   |
| 210102 | Нэмэгдэл  | 103,164,800.00   | 86,978,690.00    |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 25,328,400.00    | 17,837,835.00    |
| 210104 | Урамшуулал  | 14,504,200.00    | 14,806,289.00    |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл            | 93,936,334.00    | 96,429,052.25    |
| 210201 | Тэтгэврийн даатгал  | 64,064,379.00    | 66,837,189.83    |
| 210202 | Тэтгэмжийн даатгал  | 7,588,951.00     | 7,435,765.62     |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал   | 6,027,439.00     | 5,908,291.91     |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал                                      | 1,482,093.00     | 1,477,073.65     |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                                     | 14,773,472.00    | 14,770,731.24    |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                 | 31,647,600.00    | 34,824,400.00    |
| 210301 | Гэрэл, цахилгаан  | 4,453,800.00     | 5,243,660.00     |
| 210302 | Түлш, халаалт   | 26,250,100.00    | 28,538,440.00    |
| 210303 | Цэвэр, бохир ус   | 943,700.00       | 1,042,300.00     |
| 210304 | Байрны түрээс   | 0                | 0                |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                          | 40,436,080.00    | 29,977,656.00    |
| 210401 | Бичиг хэрэг   | 9,132,540.00     | 8,231,500.00     |
| 210402 | Тээвэр, шатахуун  | 8,623,766.00     | 12,449,000.00    |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 4,979,000.00     | 3,030,821.00     |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 900,000.00       | 632,400.00       |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 16,800,774.00    | 5,633,935.00     |

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|        |  |               |                |
|--------|--|---------------|----------------|
| 2105   | Нормативт зардал   | 800,000.00    | 800,000.00     |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 800,000.00    | 800,000.00     |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 10,707,500.00 | 16,211,200.00  |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл  | 707,500.00    | 591,200.00     |
| 210602 | Тавилга  | 0             | 0              |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 0             | 0              |
| 210604 | Урсгал засвар  | 10,000,000.00 | 15,620,000.00  |
| 2107   | Томилолт, зочны зардал   | 3,007,000.00  | 3,540,000.00   |
| 210702 | Дотоод албан томиллолт   | 3,007,000.00  | 3,540,000.00   |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 4,402,812.00  | 5,744,780.00   |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,082,500.00  | 3,389,700.00   |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 1,008,000.00  | 0              |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 1,115,900.00  | 1,915,900.00   |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар   | 113,180.00    | 108,180.00     |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 48,800.00     | 55,000.00      |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 0             | 247,500.00     |
| 210807 | Газрын төлбөр  | 34,432.00     | 28,500.00      |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 46,941,708.17 | 105,175,203.89 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 46,941,708.17 | 105,175,203.89 |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 48,647,100.00 | 28,879,443.75  |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг   | 4,000,000.00  | 2,000,000.00   |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 4,000,000.00  | 2,000,000.00   |
| 2133   | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг                          | 44,647,100.00 | 26,879,443.75  |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 44,647,100.00 | 26,879,443.75  |
| III    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)                                | 94,148,721.35 | 21,795,993.11  |
| VI     | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)                      | 94,148,721.35 | 21,795,993.11  |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

|     |   |                                 |                       |                   | / төгрөгөөр /                          |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| Код | Үзүүлэлт  | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| 1   | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 180,688,239.00                  | 316,533,602.38        | 313,932,432.21    | 811,154,273.59                         |
| 2   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 0                               | 0                     | 58,300.00         | 58,300.00                              |
| 3   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 180,688,239.00                  | 316,533,602.38        | 313,990,732.21    | 811,212,573.59                         |
| 4   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0                               | -58,300.00            | 0                 | -58,300.00                             |
| 9   | Тайлант үеийн үр дүн                            | 0                               | 0                     | 94,148,721.35     | 94,148,721.35                          |
| 10  | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 180,688,239.00                  | 316,475,302.38        | 408,139,453.56    | 905,302,994.94                         |
| 11  | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 180,688,239.00                  | 316,475,302.38        | 408,139,453.56    | 905,302,994.94                         |
| 13  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 180,688,239.00                  | 316,475,302.38        | 408,139,453.56    | 905,302,994.94                         |
| 19  | Тайлант үеийн үр дүн                            | 0                               | 0                     | 21,795,993.11     | 21,795,993.11                          |
| 20  | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл           | 180,688,239.00                  | 316,475,302.38        | 429,935,446.67    | 927,098,988.05                         |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

|        |   |                | / төгрөгөөр /  |  |
|--------|---|----------------|----------------|--|
| Код    | Үзүүлэлт  | ӨМНӨХ ОН       | ТАЙЛАНТ ОН     |  |
| I      | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)                    | 981,183,700.00 | 971,712,500.00 |  |
| 13     | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                             | 981,183,700.00 | 971,712,500.00 |  |
| 1310   | Улсын төвлөрсөн төсвөөс                                   | 981,183,700.00 | 971,712,500.00 |  |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                         | 981,183,700.00 | 971,712,500.00 |  |
| II     | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                         | 977,363,700.00 | 958,880,500.00 |  |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ   | 977,363,700.00 | 958,880,500.00 |  |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                           | 928,716,600.00 | 930,001,056.25 |  |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                         | 749,433,358.00 | 745,874,052.00 |  |
| 210101 | Үндсэн цалин  | 606,435,958.00 | 626,251,238.00 |  |
| 210102 | Нэмэгдэл  | 103,164,800.00 | 86,978,690.00  |  |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 25,328,400.00  | 17,837,835.00  |  |
| 210104 | Урамшуулал  | 14,504,200.00  | 14,806,289.00  |  |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл            | 93,936,334.00  | 97,402,624.25  |  |
| 210201 | Тэтгэврийн даатгал  | 64,064,379.00  | 67,810,761.83  |  |
| 210202 | Тэтгэмжийн даатгал  | 7,588,951.00   | 7,435,765.62   |  |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал   | 6,027,439.00   | 5,908,291.91   |  |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал                                      | 1,482,093.00   | 1,477,073.65   |  |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                                     | 14,773,472.00  | 14,770,731.24  |  |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                 | 31,647,600.00  | 34,824,400.00  |  |
| 210301 | Гэрэл, цахилгаан  | 4,453,800.00   | 5,243,660.00   |  |
| 210302 | Түлш, халаалт   | 26,250,100.00  | 28,538,440.00  |  |
| 210303 | Цэвэр, бохир ус   | 943,700.00     | 1,042,300.00   |  |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                          | 34,309,496.00  | 25,604,000.00  |  |
| 210401 | Бичиг хэрэг   | 9,201,200.00   | 6,192,500.00   |  |
| 210402 | Тээвэр, шатахуун  | 10,357,800.00  | 10,600,000.00  |  |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 4,979,000.00   | 3,030,821.00   |  |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 900,000.00     | 632,400.00     |  |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 8,871,496.00   | 5,148,279.00   |  |
| 2105   | Нормативт зардал  | 800,000.00     | 800,000.00     |  |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл                               | 800,000.00     | 800,000.00     |  |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                         | 11,180,000.00  | 16,211,200.00  |  |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл                                   | 1,180,000.00   | 591,200.00     |  |
| 210604 | Урсгал засвар   | 10,000,000.00  | 15,620,000.00  |  |
| 2107   | Томилолт, зочны зардал                                    | 3,007,000.00   | 3,540,000.00   |  |
| 210701 | Гадаад албан томилолт                                     | 0              | 0              |  |
| 210702 | Дотоод албан томилолт                                     | 3,007,000.00   | 3,540,000.00   |  |

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|        |  |               |                |
|--------|--|---------------|----------------|
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах  | 0             | 0              |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 4,402,812.00  | 5,744,780.00   |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,082,500.00  | 3,389,700.00   |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 1,008,000.00  | 0              |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 1,115,900.00  | 1,915,900.00   |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар   | 113,180.00    | 108,180.00     |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 48,800.00     | 55,000.00      |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 0             | 247,500.00     |
| 210807 | Газрын төлбөр  | 34,432.00     | 28,500.00      |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 48,647,100.00 | 28,879,443.75  |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг   | 4,000,000.00  | 2,000,000.00   |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 4,000,000.00  | 2,000,000.00   |
| 2133   | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг                          | 44,647,100.00 | 26,879,443.75  |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 44,647,100.00 | 26,879,443.75  |
| III    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)                  | 3,820,000.00  | 12,832,000.00  |
| V      | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                            | 3,820,000.00  | 12,832,000.00  |
| 22     | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 3,820,000.00  | 12,832,000.00  |
| 2200   | Дотоод эх үүсвэрээр  | 3,820,000.00  | 12,832,000.00  |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                       | 3,820,000.00  | 12,832,000.00  |
| VI     | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)                | -3,820,000.00 | -12,832,000.00 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

|        |   |                |                             | / төгрөгөөр /   |
|--------|---|----------------|-----------------------------|-----------------|
| Код    | Үзүүлэлт  | Төлөвлөгөө     | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү |
| II     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                         | 971,712,500.00 | 944,833,056.25              | 26,879,443.75   |
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ   | 971,712,500.00 | 944,833,056.25              | 26,879,443.75   |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                           | 969,712,500.00 | 942,833,056.25              | 26,879,443.75   |
| 2101   | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                         | 761,232,700.00 | 745,874,052.00              | 15,358,648.00   |
| 210101 | Үндсэн цалин  | 618,235,300.00 | 626,251,238.00              | -8,015,938.00   |
| 210102 | Нэмэгдэл  | 103,164,800.00 | 86,978,690.00               | 16,186,110.00   |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт                                     | 25,328,400.00  | 17,837,835.00               | 7,490,565.00    |
| 210104 | Урамшуулал  | 14,504,200.00  | 14,806,289.00               | -302,089.00     |
| 2102   | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл            | 105,173,100.00 | 97,402,624.25               | 7,770,475.75    |
| 210201 | Тэтгэврийн даатгал  | 73,310,700.00  | 67,810,761.83               | 5,499,938.17    |
| 210202 | Тэтгэмжийн даатгал  | 7,965,600.00   | 7,435,765.62                | 529,834.38      |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал   | 6,372,500.00   | 5,908,291.91                | 464,208.09      |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал                                      | 1,593,100.00   | 1,477,073.65                | 116,026.35      |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                                     | 15,931,200.00  | 14,770,731.24               | 1,160,468.76    |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                 | 37,401,200.00  | 34,824,400.00               | 2,576,800.00    |
| 210301 | Гэрэл, цахилгаан  | 5,170,200.00   | 5,243,660.00                | -73,460.00      |
| 210302 | Түлш, халаалт   | 31,090,100.00  | 28,538,440.00               | 2,551,660.00    |
| 210303 | Цэвэр, бохир ус   | 1,140,900.00   | 1,042,300.00                | 98,600.00       |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                          | 25,604,000.00  | 25,604,000.00               | 0.00            |
| 210401 | Бичиг хэрэг   | 6,210,000.00   | 6,192,500.00                | 17,500.00       |
| 210402 | Тээвэр, шатахуун  | 10,957,000.00  | 10,600,000.00               | 357,000.00      |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 2,687,000.00   | 3,030,821.00                | -343,821.00     |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.00     | 632,400.00                  | -32,400.00      |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 5,150,000.00   | 5,148,279.00                | 1,721.00        |
| 2105   | Нормативт зардал  | 800,000.00     | 800,000.00                  | 0.00            |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл                               | 800,000.00     | 800,000.00                  | 0.00            |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                         | 29,043,200.00  | 29,043,200.00               | 0.00            |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл                                   | 13,423,200.00  | 13,423,200.00               | 0.00            |
| 210604 | Урсгал засвар   | 15,620,000.00  | 15,620,000.00               | 0.00            |
| 2107   | Томилолт, зочны зардал                                    | 3,608,500.00   | 3,540,000.00                | 68,500.00       |
| 210702 | Дотоод албан томилолт                                     | 3,608,500.00   | 3,540,000.00                | 68,500.00       |

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|        |  |                |                |               |
|--------|--|----------------|----------------|---------------|
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 6,849,800.00   | 5,744,780.00   | 1,105,020.00  |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,489,700.00   | 3,389,700.00   | 1,100,000.00  |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 1,915,900.00   | 1,915,900.00   | 0.00          |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар   | 113,200.00     | 108,180.00     | 5,020.00      |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 55,000.00      | 55,000.00      | 0.00          |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 247,500.00     | 247,500.00     | 0.00          |
| 210807 | Газрын төлбөр  | 28,500.00      | 28,500.00      | 0.00          |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 2,000,000.00   | 2,000,000.00   | 0.00          |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг   | 2,000,000.00   | 2,000,000.00   | 0.00          |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 2,000,000.00   | 2,000,000.00   | 0.00          |
| III    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                                       | 971,712,500.00 | 944,833,056.25 | 26,879,443.75 |
| 31     | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ  | 971,712,500.00 | 944,833,056.25 | 26,879,443.75 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих  | 971,712,500.00 | 944,833,056.25 | 26,879,443.75 |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цахим төлбөрийн системд хяналт тавих талаар дотоод аудиттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/06 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант онд Шүүхийн Тамгын газар нь дараах зорилтыг дэвшүүлсэн байна.

Шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс оролцохгүйгээр “шүүгчийн хараат бус байдлыг хангаж, хамгаалах”, “шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах”, “шүүхийн хүний нөөцийг удирдах”, “шүүхийн төсөв, санхүү, дэд бүтцийг удирдах”, “шүүхийн нээлттэй байдлыг хангах, олон нийттэй харилцах” гэсэн байна.

Тус шүүхийн иргэдэд үйлчлэх төвд шүүгчийн хараат бус байдлыг хангах талаар “Нөлөөллийн мэдүүлэг”-ийн талаар шторк мэдээллийг өдөр бүр түгээж, 2021 оны байдлаар Шүүхийн шийдвэрийн цахим санд 175 шийдвэрийг байршуулан, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын сайтад иргэд, олон нийтэд шүүхийн үйл ажиллагааг мэдээлэх зорилгоор мэдээллийн буланг ажиллуулан цаг үеийн холбогдолтой мэдээ тайланг тогтмол мэдээлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитор нь тайлант онд тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Шүүхийн тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 1,029,959.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,299.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,239.6 мянган төгрөгөөр тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,796.0 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт        |
|---|------------------|------------------|-----------------|
| Б   | 1                | 2                | 3=2-1           |
| Мөнгөн хөрөнгө                                    |                  |                  | 0.0             |
| Авлага  |                  | 9,693.6          | 9,693.6         |
| Урьдчилгаа  |                  |                  | 0.0             |
| Бараа материал                                    | 4,328.0          | 440.0            | -3,888.0        |
| Үндсэн хөрөнгө                                    | 900,975.0        | 916,965.4        | 15,990.4        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>905,303.0</b> | <b>927,099.0</b> | <b>21,796.0</b> |
| Өр төлбөр   |                  |                  | 0.0             |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 905,303.0        | 927,099.0        | 21,796.0        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>905,303.0</b> | <b>927,099.0</b> | <b>21,796.0</b> |

Авлага дансны үлдэгдэл 9,693.6 мянган төгрөг нь ажилчдын хоолны мөнгийг илүү олгосон 162.0 мянга, Шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй халагдсан ажилтанд олгосон цалин 8,778.5 мянга, ажилчдын цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулж олгосон 753.1 мянган төгрөг тус тус байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 440.0 мянган төгрөг болж 3,888.0 мянган төгрөгөөр хасагдсан нь тайлант онд өмнөх оны үлдэгдэл бичиг хэрэг болон шатахууныг зарцуулсан нь нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,328.0 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 39,445.9 мянга, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 485.6 мянган төгрөгийн бараа материал үнэ хүлээн төлбөргүй авч, нийт 39,931.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 43,819.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 440.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,146,727.6 мянган төгрөг болж 121,165.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс тоног төхөөрөмж, авто машин үнэ төлбөргүй хүлээн авсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,025,562.0 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 12,832.0 мянга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.01.05-ны өдрийн 01/04 тоот албан бичгээр үнэ төлбөргүй хүлээн авсан автомашин, тоног төхөөрөмж 108,333.6 мянга, нийт 121,165.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,146,727.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Биет бус хөрөнгө нь тайлант онд 29,527.0 мянган төгрөг болж 282.5 мянган төгрөгөөр буурсан нь тайланд оны элэгдлийн зардлаар хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 927,099.0 мянган төгрөг болж 21,796.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээр нэмэгдсэн байна.

Аймгийн Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 43,576.5 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилтийн орлого 9,471.2 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 34,105.3 мянган төгрөгөөр тус тус буурч материаллаг өөрчлөлт гарсан.

Тайланд онд анх батлагдсан төсвөөс төсвийн тодотголоор 5,805.5 мянган хасаж баталсан нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 28.806.3 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, урсгал засварын зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал нь тус тус материаллаг өөрчлөлт гарсан байна.

Энэ нь тайлант онд 2 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байсан, эрүү, иргэний хурлын 2 заалыг акустик хавтангаар бүрэн доторлон шалыг шинээр сольсон, үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авснаар үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал тус тус нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 998,434.6 мянга, нийт зарлагыг 998,434.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 20,916.6 мянган төгрөгөөр бууруулж, 977,518.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Анх 977,518.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор байр ашиглалтын тогтмол зардлыг 5,753.6 мянга, эд хогшил урсгал засварын зардлыг 9,043.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 1,839.5 мянга, дотоод албан томилолтын зардлыг 600.2 мянга, нийт 17,236.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цалингийн зардлыг 20,000.0 мянга, хангамжийн бараа материалын зардлыг 3,042.0 мянга, нийт 23,042.0 мянган төгрөгөөр бууруулж, 971,712.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “70701-Шүүхийн бие даасан хараат бус” 1 хөтөлбөрийн хүрээнд 80801-үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 965,222.8 мянга, 80224-зөвлөл хороо комиссын гишүүдийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,489.7 мянга, 80802-ажил олгогчийн тэтгэмж урамшуулал арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,000.0 мянга, 82321-шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардлын арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,000.0 мянга, 82322- гэрчийн зардлын арга хэмжээг санхүүжүүлэхээр 500.0 мянга, 82,323- процессын хуульд заасан бусад зардлыг санхүүжүүлэхээр 500.0 мянга, нийт 971,712.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 971,712.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 971,712.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 944,833.0 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 26,879.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 26,879.5 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь бүрэн орон тоогоор ажиллаагүйгээс цалин, НДШ-ийн зардлыг 23,129.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,576.8 мянга, дотоод албан томилолтын зардлыг 68.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 1,105.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 971,712.5 мянга, үнэ төлбөргүй бараа материал, үндсэн хөрөнгийн орлого 108,819.2 мянга, нийт 1,080,531.7 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт 971,712.5 мянган төгрөгийг тайлагнасан байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд гүйлгээ гараагүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн “Шүүхийн тамгын газар” нь 2021 онд нийт 20,750.0 мянган төгрөгийн 7 мэдээллийг байршуулахаас 19,740.0 мянган төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус газрын өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн тул зөвлөмж өгөгдөөгүй болно.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аймгийн Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 838.5 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 838.5 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулах алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 838.5 мянган төгрөгийн 3 алдааг завсрын аудитаар залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахдаа үндсэн хөрөнгийн тайланг хөдөлгөөн гараагүй данс тус бүрээр бэлтгэн гаргаагүй
2. Тоног төхөөрөмжийн орлого 252.0 мянган төгрөгийг нярвын тайланд дутуу тусгасан
3. Бичиг хэргийн материалын зардал 25.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу, сэлбэгийн зардал 561.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд илүү тусгасан

##### 4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй

##### 4.3 Албан шаардлага өгөгдөөгүй

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Дотоод хяналттай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг тус тус зөрчсөн байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Цахим төлбөрийн баримтад тавих дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |       | Үүнээс    |       |               |     |                 |     |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|-------|-----------|-------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|     |                                     |                      |       | Залруулга |       | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн   | Тоо       | Дүн   | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| 1   | Аймгийн Шүүхийн тамгын газар        | 4                    | 838.5 | 3         | 838.5 | 0             | 0   | 0               | 0   | 1       | 0   |